



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЭМЧ, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хугацаа	Хүрэх үр дүн	Хариуцах нэгж
Нэг. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх чиглэлээр						
1.	Засгийн гарын тогтоол шийдвэрийн дагуу ажилтнуудын цалин хөлсийг тухай бүр нь шинэчлэн системд өөрчлөлт оруулна	Дээд газрын тогтоол шийдвэрийн дагуу цалин хөлс нэмэгдсэн байна.	2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчийн цалин хөлс 6%-аар нэмэгдсэн.	I-IV улирал	Тогтоол шийдвэртэй уялдан цалин хөлс нэмэгдэж эмч, мэргэжилтнүүдийн орлого нэмэгдсэн байна.	БТА, Хүний нөөцийн менежер
2.	Ажлын үр дүнг улирал тутам тооцож үр дүнгийн урамшууллыг 60 хүртэл хувиар тооцон олгоно.	Үр дүнгийн урамшууллыг 60 хүртэл хувиар тооцож олгоно.	2024 онд нийт 192,6 сая төгрөгийг үр дүнгийн урамшуулалд зарцуулсан.	I-IV улирал	Ажлын гүйцэтгэл үр дүн нэмэгдэж, ажилтнуудын бодит орлого өссөн байна.	СЭЗА, ЧА, БТА
3.	Эмч ажилтнуудын шагналын судалгааг гаргаж, хугацаа болсон холбогдох шагналын нөхцөл шаардлагыг хангасан ажилтнуудыг	Төрийн дээд одон медаль болон салбарын шагналаар шагнагдсан байна.	-	I-IV улирал	Төрийн дээд шагналаар шагнагдсан ажилтнуудын тоо өссөн байна.	БТА, Хүний нөөцийн менежер

	шагналд тодорхойлон шийдвэрлүүлнэ.					
4.	Ажилтнуудын орон сууцны нөхцөл байдлын талаарх судалгааг гаргаж, нэн шаардлагатай ажилтанд дэмжлэг үзүүлэх ажлыг Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран зохион байгуулна.	Ажилтны амьдрах орчин нөхцөл сайжрах боломжийг бүрдүүлнэ.	-	I-IV улирал	Шаардлагатай ажилтанд бодит дэмжлэг хүрсэн байна.	БТА, Хүний нөөцийн менежер
Хоёр. Ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, ажлын байрны стандарт, аюулгүй байдлыг хангах, ажилтнуудын ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр						
1.	Нэн шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгааг гаргаж, төсвийн төсөлд санхүүжилтийг тусгуулан батлуулна.	Шаардлагатай тоног төхөөрөмжийн төсөв шийдвэрлэгдсэн байна.	-	I-IV улирал	2026 онд шинэ тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн хангалт хийгдэх боломж бүрдэнэ.	СЭЗА, ЭСТҮА
2.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан хамгаалах хувцас хэрэглэлээр бүрэн хангах, тогтмол хугацаанд шинэчлэн олгоно.	Шаардлага хангасан хувцас хэрэгслээр хангана.	11 төрлийн ажлын дүрэмт хувцсаар эмгэг судлаач эмч, лабораторийн техникч болон бусад ажилтнуудыг хангасан.	I-IV улирал	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны нөхцөл шаардлага хангагдана.	СЭЗА, БТА
3.	Ажилтны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хугацаанд авч, гарч буй асуудалд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Ажлын байрны сэтгэл ханамжийн хувь нэмэгдсэн байна.	2024 онд ажилтнуудаас авсан судалгаа 72,3%	II, V улирал	Ажлын байрны сэтгэл ханамжийн хувь 100%-д хүрсэн байна.	ЧА
4.	Ажлын байрны ялгаварлан гадуурхалт, дарамт хүчирхийллээс ангид	Ажилтнуудын мэдлэг мэдээлэл нэмэгдсэн байна.	-	II, IV улирал	Ажлын байрны ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэлгүй орчин	БТА, Хуулийн зөвлөх

	орчин нөхцөлийн талаарх ажилтнуудын ойлголт мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх хүрээнд мэргэжлийн байгууллага болон хуулийн зөвлөхөөс хамтран сургалт зохион байгуулна.				нөхцөлийн талаарх ажилтнуудын мэдлэг ойлголт сайжирч, тохиолдлыг шийдвэрлэх арга замд суралцсан байна.	
Гурав. Ажилтнуудын сурч хөгжих боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн ур чадварын тасралтгүй хөгжлийг дэмжих, сургалт, дадлагажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр						
1.	Удирдах ажилтнуудад удирдлагын манлайлал, менежментийн чиглэлийн чадавхжуулах сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулна.	Байгууллагын удирдах ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллуулна.	Эрүүл Мэндийн Яам НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Харвардын Их Сургуулийн “Эрүүл Мэндийн Салбарын Манлайлал” сэдэвт 1 жилийн хугацаатай тэтгэлэгт хөтөлбөрт тус төвийн ССЭШГХА-ны дарга хамрагдсан.	I-IV улирал	Удирдах ажилтнууд сурч хөгжсөнөөр хүний нөөцийн тогтвортой ажиллах нөхцөл бүрдэнэ.	Удирдлага
2.	Мэргэжлийн зэргийн судалгааг гаргаж, нөхцөл шаардлагад хүрсэн ажилтнуудыг мэргэжлийн зэргээ ахиулахад нь дэмжлэг үзүүлнэ.	Зэрэгтэй ажилтнуудын тоо нэмэгдсэн байна.	Ахлах зэрэгтэй 6, тэргүүлэх зэрэгтэй 5 эмч эмнэлгийн мэргэжилтэн байна.	I-IV улирал	Мэргэжлийн зэрэг хамгаалсан эмч мэргэжилтний тоо нэмэгдсэн байна.	ССЭШГХА

3.	Сургалтын төлөвлөгөөний дагуу холбогдох сургалтад хамрагдах нөхцөл боломжийг хангаж ажлын зохицуулалт хийнэ.	Сургалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	2024 онд сургалтын төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн. АЗ гэрчилгээ олгох сургалтад 4 ажилтан хамрагдсан.	I-IV улирал	Эмч мэргэжилтнүүдийн сурч хөгжих нөхцөл баталгаа хангагдсан байна.	Удирдлага
4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулна.	Үйлдвэрлэлийн осол гэмтэлгүй ажилласан байна.	2 удаагийн сургалт зохион байгуулсан.	I-IV улирал	Мэргэжлээс шалтгаалах өвчлөл, үйлдвэрлэлийн осол гэмтэл бүртгэгдээгүй байна.	ХАБЭА
Дөрөв. Эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх, ажилтнуудын эрүүл мэндийг сахин хамгаалах чиглэлээр						
1.	Эрүүл мэндийг үзлэгт хамруулах ажлыг жил бүр зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношилгоонд хамруулна.	Ажилтнууд эрүүл мэндээ сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дадал хэвшилтэй болсон байна.	90% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан.	I-IV улирал	Ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт 100% хамруулна.	ЧА, ХСХБ
2.	Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээгээр хүнд өвчин эмгэг оношлогдсон ажилтанд байгууллагын зүгээс боломжит дэмжлэг туслалцаа үзүүлнэ.	Хүнд өвчтэй ажилтанд дэмжлэг үзүүлсэн тоо	-	I-IV улирал	Ажилтанд бодит дэмжлэг хүрсэн байна.	ЧА, СЭЗА
3.	Ажлын байрны эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж, ажлын байран	Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшинэ.	-	I-IV улирал	Хөдөлмөрийн чадвар түр алдалт багассан байна.	Бүх алба

	дахь дасгал хөдөлгөөн хийх дадлыг хэвшүүлнэ.					
Тав. Нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, хамт олонч эерэг уур амьсгалыг бүрдүүлэх чиглэлээр						
1.	Эмч мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлж, байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийтэд сурталчлан таниулах зэргээр хамтран ажиллана.	Эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл нэмэгдсэн байна.	-	I-IV улирал	Эмч мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх идэвх санаачилга нэмэгдэнэ.	ССЭШХА, Сүлжээний инженер
2.	Урлаг спортын арга хэмжээ, хүмүүнлэгийн ажилд байгууллага хамт олноороо оролцоно.	Нэгдмэл зорилготой, эерэг хандлагатай хамт олон	-	I-IV улирал	Ажлын байрны сэтгэл ханамжийн хувь нэмэгдэнэ.	ҮЭХороо
3.	Харилцаа хандлага, сэтгэл зүйн эрүүл дадал хэвшил олгох чиглэлийн сургалтад хамруулна.	Сэтгэл зүйгээ зөв удирдах дадал хэвшилд суралцсан байна.	-	I-IV улирал	Ажлын байрны сэтгэл ханамжийн хувь нэмэгдэнэ.	ССЭШХА, БТА

Төлөвлөгөө боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн албаны дарга



Б.Отгонгэрэл